

**Төрийн албан хаагчийн 2023 оны
нийгмийн баталгааны тайлан**

№	Үйл ажиллагааны чиглэл	Биелэлт
1	Албан хаагчдыг ажлаас хөндийрүүлэхгүйгээр сургалтад харуулах сургалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх	Тайлант хугацаанд албан хаагчдыг ажлын байрнаас нь хөндийрүүлэхгүйгээр байгууллагын дотоод сургалт 7-г зохион байгуулсан.
2	Засгийн газрын тогтоосон журмын дагуу үйл ажиллагааны үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох	-Эхний хагас жилийн үйл ажиллагааны үр дүнгийн мөнгөн урамшуулалд 5 албан хаагчид 3847.8 мянган төгрөгийг олгосон байна.
3	Мөнгөн бус урамшууллын аливаа аргыг судлаж үзэн хууль тогтоомжид нийцүүлэн олгох	-
4	Ажлын байрны тохижилтыг хийж, эрүүл аюулгүй сүүлийн үеийн техник тоног төхөөрөмжөөр хангах	Албан тасалгааны тохижилтыг хийж, сүүлийн үеийн техник тоног төхөөрөмжөөр хангахад 8709,5 мянган төгрөгийг зарцуулсан. -Тоног төхөөрөмж, эд хогшил худалдан авахад 8209.5 мянган төгрөг -Өрөөний гэрэлтүүлэг шинэчлэх, тохижуулахад 500.0 мянган төгрөг тус тус байна.
5	Ажил үүргээ гүйцэтгэх шаардлагатай бичиг хэргийн хэрэгслээр хангах	Албан хаагчдыг ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай бичиг хэргийн материалаар тогтмол ханган ажилласан бөгөөд 1875.8 мянган төгрөгийг бичиг хэргийн материалыг олгосон байна.
6	Унаа, хоолны зардал олгох	Унаа хоолны мөнгийг тогтмол олгож байгаа бөгөөд зах зээлийн үнийн өсөлттэй уялдуулан ажлын нэг өдөрт 9000 төгрөг болгосон.
7	Ажилтан, албан хаагчийн хөдөлмөрийн нөхцөл, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны шаардлагад нийцсэн ажлын хамгаалах хэрэгсэл, багаж хэрэгслээр хангах	Албан хаагчдийн хөдөлмөрийн нөхцөл, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангахын тулд хамгаалах хэрэгсэл, бээлий, хуруувчаар хангаж байна.
8	Интернэт, дотоод сүлжээний байнгын тасралтгүй ажиллагааг хангах	Интернэт дотоод сүлжээний 24 цагийн тасралтгүй ажиллагааг хангах үүднээс интернет төхөөрөмж болон сүлжээний утсыг 182,6 мянган төгрөгөөр сольж сайжруулсан.
9	Албан хаагчдын цалинг нэмэгдүүлэхдээ ажилласан жил болон ажлын үр дүнг харгалзан зэрэг дэв, эрдмийн зэрэг,	Албан хаагчдын цалинг нэмэгдүүлэхдээ ажилласан жилд үндэслэн жил бүр нэмэгдэл олгож байгаа бөгөөд ажлын үр дүнг харгалзан

	мэрэгшлийн зэрэг, ур чадварын нэмэгдэл олгох	хууль журамд заасны дагуу 3 албан хаагч зэрэг дэв авсан. Мөн 1 албан хаагчид мэргэшсэн нягтлан бодогчийн зэргийн нэмэгдлийг шинээр олгож нийт 3 албан хаагч зэргийн нэмэгдэл авч байна. Ажлын гүйцэтгэлийг үнэлж төрийн үйлчилгээний 1 албан хаагчид ур чадварын нэмэгдлийг сар бүр олгож байгаа. - 6 албан хаагчид зэрэг дэвийн нэмэгдэл 10885.3 мянган төгрөг - 3 албан хаагчид мэргэшсэн нягтлан бодогчийн нэмэгдэл 3946.9 мянган төгрөг - 1 албан хаагчид ур чадварын нэмэгдэл 2176.8 мянган төгрөгийг тус тус олгосон байна.
10	Төрийн албан хаагчийн ээлжийн амралтыг биеэр эдлүүлэх, албан ажлын зайлшгүй шаардлагын үүднээс ээлжийн амралтаа биеэр эдлээгүй тохиолдолд түүний зөвшөөрснөөр 1.5 сарын албан тушаалын цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгох	Байгууллагын нийт 7 албан хаагчийн 4 албан хаагчийн ээлжийн амралтыг биеэр эдлүүлэн 8670.5 мянган төгрөгийн амралтын цалинг олгосон байна. Шинээр орсон 3 албан хаагчийн амрах хугацаа болоогүй байна.
11	Гэр бүлийн гишүүн болон өөрөө хүндээр өвчилж эмнэлэгт удаан хугацаагаар эмчлүүлсэн ажилтан албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусламж олгоно.	Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч Э.Цэлмэгбаярт нарийн мэргэжлийн шинжилгээ хийлгэхэд 600.0 мянган төгрөгийн тусламж үзүүлсэн.
12	Шинэ төрсөн хүүхдэд тэтгэмж олгоно	Тайлант хугацаанд шинэ төрсөн 1 хүүхдэд 500.000 төгрөгийн мөнгөн тэтгэмж олгосон
13	Албан хаагчдын хүүхдүүдэд хүүхдийн баярыг тохиолдуулан бэлэг олгох	Албан хаагчдын 16 хүүхдэд 50,000 төгрөг нийт 800,000 төгрөгийн бэлэг олгосон.
14	Төрийн албан хаагчийг нарийн мэргэжлийн эмч нарын урьдчилан сэргийлэх үзлэгт жилд 1 удаа хамруулах,	Албан хаагчдыг урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэг, оношлогоонд бүрэн хамруулсан.
15	Албан хаагчийн спорт арга хэмжээг тогтмолжуулах	7 хоног бүрийн 2 дахь өдрийн орой албан хаагчид зааланд тогтмол хамрагдаж байна.
16	Албан хаагчийн хууль бусаар ажлаас халахгүй байх.	Албан хаагчийг ажлаас халах, чөлөөлөх аливаа шийдвэр гаргаагүй бөгөөд байгууллагын албан хаагчид тогтвор сууршилтай ажиллаж байна.

Төлөвлөгөө биелэлт гаргасан.

Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч

Э.Цэлмэгбаяр